

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл

3. САНХҮҮГИЙН ЗАХЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД

ЗОРИЛТ 3.3. Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хүрээнд иргэд, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн суурь мэдлэгийг дэмжинэ

Үндэслэл

Монголбанк, Сангийн яам, БСШУЯ, СЗХ хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг 2015 онд баталж 2016-2021 оны хооронд дараах 4 тэргүүлэх чиглэлээр хэрэгжүүлжээ. Үүнд: 1) Сургуулийн насанд санхүүгийн мэдлэг олгох; 2) Залуу үед санхүүгийн мэдлэг олгох; 3) Хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох; 4) Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гэсэн чиглэлүүд багтаж байна. Цаашид тус хөтөлбөрийн хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дараагийн шатны стратегийг боловсруулахын тулд иргэдийн санхүүгийн боловсролыг дэмжих ажлын үр дүнг үнэлэх шаардлагатай.

Монголбанкаас 2020 онд “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн хүрээнд хийсэн түүвэр судалгааны үр дүнгээр бичил, жижиг дунд үйлдвэрлэл (БЖДҮ) эрхлэгчдийн өдөр тутмын үйл ажиллагаанд санхүүгийн мэдлэг, боловсрол зайлшгүй хэрэгцээтэй байгааг тогтоосон. Иймд холбогдох дэд хөтөлбөрийг Европын сэргээн босголт, хөгжлийн банкны дэмжлэгтэй боловсруулан 2021 онд Монголбанкны Ерөнхийлөгч, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын хамтарсан тушаалаар баталлаа. Тус хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж 2022 онд бичил, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлнэ.

Стратеги

- Санхүүгийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээнүүд нь судалгаанд үндэслэнэ.
- Сургагч багш нарыг бэлтгэж, мэдээллээр тогтмол хангаж, чадавхжуулна.
- Сургалт, семинар, уулзалтуудын үр дүнг технологийн дэвшлийг ашиглан сайжруулна.
- Гарын авлага, сургалтын материалуудыг шинэчилж боловсруулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад санхүүгийн суурь мэдлэг олгох:

- Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгагдсан сонгон судлах “Бизнес судлал” хичээлийн хүртээмжийг дээшлүүлэх чиглэлд ажиллана.
- “Дэлхийн мөнгөний долоо хоног”, “Дэлхийн хуримтлалын өдөр” аянуудыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

Их дээд сургуулиудын оюутнуудын санхүүгийн мэдлэг олгох:

- “Хувь хүний санхүү” хичээлийн хүртээмжийг дээшлүүлэх, идэвхжүүлэлтийн арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулна.
- “Тинк Банк” хөтөлбөрийн хүрээнд оюутнуудын судалгаа, эрдэм шинжилгээ хийх идэвхийг нэмэгдүүлж, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулна.

Хөдөө, орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох:

- Сургагч багш нарыг бэлтгэнэ.

- Монголбанкны хэлтэс, салбаруудын ажилтнуудыг мэдээлэл, гарын авлагаар хангаж, иргэдэд санхүүгийн боловсролын ач холбогдлыг ойлгуулах, мэдлэг түгээх ажлыг дэмжинэ.
- Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана
- Орон нутгийн иргэдэд сургалт, контент хийж үр дүнтэй түгээхэд технологийн дэвшлүүдийг ашиглана.

Бичил, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн боловсрол олгох дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх:

- Оролцогч талуудтай хамтран БЖДҮ эрхлэгчдэд чиглэсэн гарын авлага бэлтгэнэ.
- БЖДҮ эрхлэгчдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн бусад төсөл, үйл ажиллагаануудтай хамтран ажиллаж, сургагч багш нарын тоог нэмэгдүүлнэ.

Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэх, цаашид сунгах:

- Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн үр дүнг харуулах, иргэдийн санхүүгийн мэдлэгийн түвшинг тогтоох судалгаа хийнэ.
- Судалгааны үр дүнд үндэслэн дараагийн шатны хөтөлбөрийг боловсруулна.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл

3. САНХҮҮГИЙН ЗАХЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД

ЗОРИЛТ 3.3 Санхүүгийн хүртээмжийг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор иргэд, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлнэ.

Үндэслэл

Санхүүгийн зах зээлийн хөгжил, улс орны эдийн засгийн хөгжил, тогтвортой байдалд зах зээлд оролцогчид, иргэдийн санхүүгийн мэдлэг боловсрол чухал үүрэгтэй. Монголбанк, Сангийн яам, БСШУЯ (хуучин нэрээр), СЗХ хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр, 2016-2021”-ийг 2 үе шаттайгаар, дараах 4 тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлж байна. Үүнд: 1) Сургуулийн насанд санхүүгийн мэдлэг олгох; 2) Залуу үед санхүүгийн мэдлэг олгох; 3) Хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох; 4) Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох зэрэг багтана. Тус хөтөлбөрийн анхан шатны үнэлгээг 2019 онд Дэлхийн банкнаас гаргасан аргачлалыг удирдлага болгон, тоон болон чанарын судалгааны аргуудыг хослуулан гүйцэтгэсний үр дүнд “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр” амжилттай хэрэгжиж, хөтөлбөрийн зорилго, зорилтууд хангагдаж байна гэсэн дүгнэлтэд хүрсэн. Гэхдээ цаашид уг хөтөлбөрийн хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай тул хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх нь зүйтэй.

Ковид-19 цар тахлын тархалтаас үүдэлтэй эдийн засгийн хүндрэлийн үед өрхийн санхүүгийн оновчтой удирдлага, санхүүгийн суурь мэдлэгийн ач холбогдол нэмэгдэж байна. Түүнчлэн бичил, жижиг дунд үйлдвэрлэгчдийн санхүүгийн зах дээрх бүтээгдэхүүн үйлчилгээний талаарх мэдлэг, бизнесийн хөрөнгө оруулалт болон төсвийн удирдлагад шаардлагатай мэдлэг чадварыг сайжруулах нь эдийн засаг дахь ажил эрхлэлт, бизнесийн үйл ажиллагаанд эерэг нөлөөтэй. Иймд иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх ажлыг үргэлжлүүлэхийн зэрэгцээ, 2019 онд Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас Монгол Улсын Бичил, жижиг, дунд үйлдвэр /БЖДҮ/-ийн санхүүгийн хүртээмжийг сайжруулах “Харилцан үнэлгээний тайлан”-д зөвлөсний дагуу “Олон нийтийн санхүүгийн мэдлэг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-т БЖДҮЭ-дэд чиглэсэн дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх шаардлага үүсэж байна.

Стратеги

- Санхүүгийн боловсролоор дамжуулж санхүүгийн зах зээлийн хөгжил, эдийн засгийн тогтвортой байдалд дэмжлэг үзүүлнэ
- Сургалт, семинар, гарын авлагуудыг зорилтот бүлэг тус бүрт тохируулж боловсруулна;
- Мэдлэгийн хүртээмжийг дээшлүүлэхэд технологийн дэвшлийг ашиглана;
- Боловсролын хүртээмж, чанарыг сайжруулахад төрийн болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана.

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад санхүүгийн суурь мэдлэг олгоно:

- БСШУСЯ-ны ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгагдсан сонгон судлах “Бизнес судлал” хичээлийн хүртээмжийг дээшлүүлнэ;

- Санхүүгийн мэдлэг түгээх арга хэмжээг олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ
- Их дээд сургуулиудын оюутнуудын санхүүгийн мэдлэгийг дээшлүүлнэ;
- “Хувь хүний санхүү” хичээлийг мэргэжил харгалзахгүйгээр их дээд сургуулиудад үзэж буй оюутан залууст зориулсан идэвхжүүлэлтийн арга хэмжээнүүдийг үе шаттайгаар зохион байгуулна;

Хөдөө, орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох ажлын хүрээнд:

- Санхүүгийн мэдлэг түгээх сургагч багш нарыг бэлтгэнэ;
- Энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана;
- Орон нутгийн иргэдэд сургалт, контент хийж үр дүнтэй түгээхэд чиглэсэн технологийн дэвшлүүдийг ашиглана

Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөрийн үр дүнг дүгнэх судалгаа хийнэ.

Сургалт, семинарыг цахим хэлбэрээр, зайнаас зохион байгуулна.

Бичил, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн боловсрол олгох дэд хөтөлбөрийг төрийн болон холбогдох олон улсын байгууллагуудтай хамтран боловсруулна:

- Цогц гарын авлага боловсруулж, эх бэлтгэн хэвлүүлнэ;
- Сургалт, семинар зохион байгуулна;
- Богино хэмжээний онлайн сургалтын видео хичээл бэлтгэнэ

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2020 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл

3. САНХҮҮГИЙН ЗАХЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД

ЗОРИЛТ 3.3 Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлыг сайжруулна.

Үндэслэл

Иргэдийн эдийн засгийн болон санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх нь мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулах, санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад чухал ач холбогдолтой.

Сүүлийн жилүүдэд банкны салбар эрчимтэй хөгжиж санхүүгийн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ олноор нэвтэрч байна. Хэрэглэгчдийн санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдээлэл, ойлголт дутмаг байгаа нь дунд болон урт хугацаанд санхүүгийн хүндрэлд орох эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Иймд олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд Монголбанк, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Санхүүгийн зохицуулах хороо хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж байгаа болно. Үүнээс гадна Засгийн газраас 2017 онд баталсан “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т энэ чиглэлээр тодорхой арга хэмжээг тусгасан.

Стратеги

“Санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг дараах 4 тэргүүлэх чиглэлээр хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад санхүүгийн мэдлэг олгох;
- Оюутан, залуучуудад санхүүгийн мэдлэг олгох;
- Орон нутаг, суурин газраас алслагдсан иргэдэд санхүүгийн мэдлэг олгох;
- Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох.

ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад санхүүгийн суурь мэдлэг олгоно:

- БСШУСЯ-ны ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгасан сонгон судлах “Бизнес судлал” хичээлийн хүртээмжийг дээшлүүлнэ;
- Санхүүгийн мэдлэг түгээх арга хэмжээг олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ;

Их дээд сургуулийн оюутнуудын санхүүгийн мэдлэгийг дээшлүүлнэ:

- “Хувь хүний санхүү” хичээлийг мэргэжил харгалзахгүйгээр их дээд сургуулиудад нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ;

Хөдөө, орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох ажлын хүрээнд:

- Санхүүгийн мэдлэг түгээх сургагч багш нарыг үргэлжлүүлэн бэлтгэж, санхүүгийн зах зээл, хууль эрх зүйн мэдлэгийн түвшинг дээшлүүлэх, өөрт тохиромжтой санхүүгийн бүтээгдэхүүн сонгох зэрэг үр чадварыг нэмэгдүүлэхэд сургалтыг чиглүүлнэ;
- Энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана;

Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох ажлыг хэрэгжүүлнэ:

- Олон нийтэд санхүүгийн суурь мэдлэг олгох сургалтыг цахим хуудас болон шинэлэг технологид суурилсан арга хэрэгслээр олгож, хүртээмжийг сайжруулахад анхаарна;
- Төсөвчин аппликейшний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Цаашид байгаа нөөц бололцоог ашиглан бичил, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн боловсрол олгох үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл

3. САНХҮҮГИЙН ЗАХЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД

ЗОРИЛТ 3.2 Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлыг эрчимжүүлж, хамрах хүрээг өргөжүүлнэ.

Үндэслэл

Иргэдийн эдийн засгийн болон санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх, мөнгөний бодлогын шийдвэр, түүний үндэслэлийг тайлбарлах нь макро эдийн засгийн төлөвийн талаарх олон нийтийн хүлээлтийг удирдахад чухал ач холбогдолтой.

Сүүлийн жилүүдэд банкны салбар эрчимтэй хөгжиж санхүүгийн шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ олноор нэвтэрч байна. Банкны зарим харилцагчийн хувьд эдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар мэдээлэл, ойлголт дутмаг байгаагаас шалтгаалж өөрийн хэрэгцээнд нийцсэн сонголтыг хийж чадахгүй байх тохиолдол гарсаар байна. Энэ нь банкны харилцагчийг дунд болон урт хугацаанд санхүүгийн хүндрэлд орох эрсдэлийг бий болгож байна.

Иймд олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авах шаардлага гарсаар байна. Энэ хүрээнд Монголбанк, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Санхүүгийн зохицуулах хороо хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж байна. Үүнээс гадна Засгийн газраас 2017 онд баталсан “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-т энэ чиглэлээр тодорхой арга хэмжээ тусган хэрэгжүүлж байна.

Стратеги

“Санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг дараах 4 тэргүүлэх чиглэлээр хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад санхүүгийн мэдлэг олгох;
- Оюутан, залуучуудад санхүүгийн мэдлэг олгох;
- Орон нутаг, суурин газраас алслагдсан иргэдэд санхүүгийн мэдлэг олгох;
- Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад санхүүгийн суурь мэдлэг олгоно:

- БСШУСЯ-ны ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгасан сонгон судлах “Бизнес судлал” хичээлийн хүртээмжийг дээшлүүлнэ;
- Санхүүгийн мэдлэг түгээх арга хэмжээг олон улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ;

Их дээд сургуулиудын оюутнуудын санхүүгийн мэдлэгийг дээшлүүлнэ:

- “Хувь хүний санхүү” хичээлийг мэргэжил харгалзахгүйгээр их дээд сургуулиудад нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ;

Хөдөө, орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох ажлын хүрээнд:

- Санхүүгийн мэдлэг түгээх сургагч багш нарыг бэлтгэнэ;
- Энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана;

Бичил, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд санхүүгийн боловсрол олгох арга хэмжээг үргэлжлүүлнэ.

Олон нийтэд санхүүгийн суурь мэдлэг олгох сургалтыг цахим хуудас болон шинэлэг технологид суурилсан арга хэрэгслээр олгож, хүртээмжийг сайжруулна. Үүнд сургалтын нэр төрөл, арга хэлбэрийг нэмэгдүүлэх асуудалд анхаарч ажиллана.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл

3. САНХҮҮГИЙН ЗАХЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД

ЗОРИЛТ 3.3 Олон улсын, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

Үндэслэл

Иргэдийн эдийн засгийн мэдлэг, ялангуяа санхүүгийн мэдлэгийн түвшин нь мөнгөний бодлого шийдвэр, түүний үндэслэлийг тайлбарлах замаар инфляцийн болон зах зээлийн хүлээлтийг зохистой удирдахад чухал нэг нөхцөл болдгийг судлаачид онцолж байна. Мөн иргэдийн санхүүгийн шийдвэр гаргах чадавхийг дээшлүүлэх нь мөнгөний бодлогын нөлөөллийг нэмэгдүүлэхээс гадна өрхийн орлогод дэмжлэг үзүүлэх, санхүүгийн эрсдэлээс хамгаалах зэргээр хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалдаг тул нийгмийн ач холбогдол өндөр юм.

Санхүүгийн секторт шинэ технологи, ололт нэвтрэх хирээр улс орны хэмжээнд төдийгүй олон улсын хэмжээнд санхүүгийн үйлчилгээний цар хүрээ тэлж, бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл, тэдгээрийг ашиглахад хялбар болж хүртээмж нэмэгдсээр байна. Иймээс ихэнх хөгжингүй орнууд санхүүгийн үйлчилгээг хянах тогтолцоогоо хөгжүүлэхээс гадна иргэдийнхээ санхүүгийн боловсролыг дээшлүүлэх замаар санхүүгийн болзошгүй эрсдэлээс сэргийлэхэд илүүтэй анхаарал хандуулж эхлээд байна.

Дэлхийн банк 2012 онд Монгол Улсын санхүүгийн салбар дахь бүтээгдэхүүн үйлчилгээг авч буй харилцагчдын эрх ашгийг хамгаалж буй байдал болон тэдгээрийн эдийн засаг, санхүүгийн мэдлэг, боловсролын өнөөгийн байдлыг олон улсын түвшинтэй харьцуулсан судалгаа анх удаа хийжээ.

Уг судалгааны тайланд иргэдийн дийлэнх хэсэг нь санхүүгийн бүтээгдэхүүний талаар мэдээлэлтэй, энгийн тооцон бодох үйлдлүүдийг сайтар мэдэж байгаа боловч ирээдүйд хийх хөрөнгө оруулалт, хадгаламж зэрэг санхүүгийн шийдвэрийн талаар ойлголт багатай гэж онцолжээ. Тухайлбал, судалгаанд хамрагдагсдын 97 хувь нь энгийн тооцон бодох үйлдлүүдийг хийж чадаж байсан ба 86 хувь нь даатгалын бүтээгдэхүүний зорилгын талаар ойлголттой байсан боловч, 30 орчим хувь нь хүүгийн талаар, 60-аас дээш хувь нь инфляци хадгаламжид нь хэрхэн нөлөөлөх талаар ойлголтгүй байжээ. Мөн уг судалгаанд Монголын эрх бүхий байгууллагуудаас харилцагчдын эрх ашгийг хамгаалж буй байдал болон харилцагчдын банк санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдлэг дутмаг байгаа талаар дүгнэжээ.

Иймээс Монголбанк, Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Санхүүгийн зохицуулах хороо хамтран Дэлхийн банкны техник туслалцааны хүрээнд “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх дунд хугацааны хөтөлбөр”-ийг боловсруулан Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр хэлэлцэж 2015 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн хамтарсан тушаалаар баталж энэхүү хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж эхэлсэн.

Энэхүү хөтөлбөр хэрэгжсэнээр иргэдийн санхүүгийн мэдлэг дээшилж, санхүүгийн зохистой шийдвэр гаргах чадвар нэмэгдэж, урт хугацаатай хуримтлал болон санхүүгийн хөрөнгө оруулалт нэмэгдэж, санхүү, банкны системд итгэх олон нийтийн итгэл дээшилж, цаашлаад Монгол Улсын эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлт хөгжилд бодитой хувь нэмэр үзүүлнэ.

Стратеги

Олон улсын түршлагаас харахад олон төрлийн тэргүүлэх чиглэлийн хүрээнд санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Гэвч хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөөц бололцоо хязгаарлагдмал байдаг тул хамгийн үр нөлөө бүхий тэргүүлэх чиглэлүүдийг сонгон хэрэгжүүлэх нь чухал юм.

Санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг дараах 4 тэргүүлэх чиглэлийн хүрээнд хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Сургуулийн насанд санхүүгийн мэдлэг олгох;
2. Залуу үед санхүүгийн мэдлэг олгох;
3. Хөдөө, орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох;
4. Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох.

Хэрэгжүүлэх арга хэмжээ

Сургуулийн насанд санхүүгийн мэдлэг олгох хүрээнд:

- Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хөтөлбөрт бага наснаас эхлэн хувийн санхүүгээ удирдах талаар анхан шатны ойлголт, мэдлэг олгох агуулгыг багтаах;
- Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт оруулахад техникийн туслалцаа үзүүлэх
- Санхүүгийн мэдлэг олгох талаар ерөнхий боловсролын сургуулийн багш нарын чадавхыг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх чиглэлийн сургалтыг БСШУСЯ-тай хамтран зохион байгуулах, холбогдох ном, гарын авлагыг боловсруулах;
- Ерөнхий боловсролын сургуулийн бага, суурь ангийн сурагчдад зориулсан санхүүгийн мэдлэг олгох агуулгыг “Иргэний боловсрол”, “Амьдрах чадварт суралцах” болон “Хичээлээс гадуурх ажил” хичээлийн сургалтын хөтөлбөрт оруулах

Залуу үед санхүүгийн мэдлэг олгох хүрээнд:

- Мэргэжил харгалзахгүйгээр их дээд сургуулиудад “Хувь хүний санхүү” хичээлийг нэвтрүүлэхэд техникийн туслалцаа үзүүлэх
- Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв /МСҮТ/-ийн хичээлийн хөтөлбөрт санхүүгийн мэдлэг олгох хичээлийг ХНХЯ-тай хамтран нэвтрүүлэх
- Зорилтот бүлгүүдэд судалгаа хийж, санхүүгийн боловсролыг хүртээмжийг нэмэгдүүлэх

Хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох хүрээнд:

- БСШУЯ-ны харьяа Насан түршийн боловсролын төвийн сургалтын хөтөлбөрт санхүүгийн мэдлэг олгох хичээлийг оруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх.
- Орон нутаг дахь Монголбанкны салбар, хэлтсээр дамжуулан төрийн болон төрийн бус байгууллагатай санхүүгийн мэдлэг олгох чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх
- Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох хүрээнд:
- Интэрнет, цахим ертөнц өргөжиж байгаатай холбогдуулан [www. sankhuuginbolovsrol.mn](http://www.sankhuuginbolovsrol.mn) цахим хуудсыг хөгжүүлж, олон нийтэд түгээх
- Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан санхүүгийн боловсрол олгох
-

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл

3. САНХҮҮГИЙН ЗАХЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД

ЗОРИЛТ 3.3. Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийг холбогдох байгууллагатай хамтран үе шаттай хэрэгжүүлнэ.

“Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”(ОНССМДХ)-ийг 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, БСШУЯ-ны хамтарсан А-142/282/Б/403.274 дугаар тушаалаар баталсан. Хөтөлбөрийн дөрвөн тэргүүлэх чиглэл болох сургуулийн насанд санхүүгийн мэдлэг олгох, залуу үед санхүүгийн мэдлэг олгох, хөдөө орон нутагт санхүүгийн мэдлэг олгох, цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. 2016 онд ОНССМДХ-ийн хэрэгжүүлэх ажлын хүрээнд гарах холбогдох зардлыг Монголбанк хариуцан ажиллаж байна.

Сургуулийн насанд санхүүгийн мэдлэг олгох тэргүүлэх чиглэлийн хүрээнд Ерөнхий боловсролын 10, 11, 12 дугаар ангийн хичээлийн хөтөлбөрт БСШУ-ны сайдын 2015 оны А/320 дугаар “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” тушаалаар батлагдсан “Бизнес судлал” хичээлийн хөтөлбөрийг БСШУЯ болон Монголбанк хариуцан ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд 2016 онд ерөнхий боловсролын 10,11,12 39 дугаар ангийн “Бизнес судлал” сургалтын хөтөлбөр, 10 дугаар ангийн сурах бичиг, багшийн ном болон бага, суурь боловсролын ангиудад зориулсан санхүүгийн суурь мэдлэг олгох зөвлөмжийг боловсруулах ажлыг 2016 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 1116/292 тоот гэрээгээр БСШУЯ, Монголбанк хамтран эхлүүлээд байна.

Насанд хүрэгчдэд зориулсан санхүүгийн боловсролын хөтөлбөрийг БСШУЯ-ны харьяа Насан түршийн боловсролын үндэсний төвтэй Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А1/252 тоот албан бичгээр тавьсан саналыг үндэслэн 2016-04-05-ны өдрийн 19.1116/203 тоот ажил гүйцэтгэх гэрээний дагуу хөтөлбөр боловсруулах ажлыг хамтран гүйцэтгэхээр болсон. Хичээлийн хөтөлбөрийг боловсруулах баг нь 4 багш, 2 экспертийн бүрэлдэхүүнтэй ажиллах бөгөөд 2016 оны IV дүгээр улиралд багтаан хийж гүйцэтгэхээр тусгагдсан болно.

Хөтөлбөрийн залуу үед санхүүгийн мэдлэг олгох, хөдөө орон нутгийн иргэдэд санхүүгийн мэдлэг олгох тэргүүлэх чиглэлийн хүрээнд Хөдөлмөрийн яамтай хамтран ажиллахаар Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 01 дүгээр сарын 21- ний өдрийн А1/93 тоот албан бичгээр тавьсан санал, Мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрийн “Бизнес, аж ахуй эрхлэх чиг баримжаа олгох” хичээлийн агуулгад “Санхүүгийн суурь мэдлэг, хувь хүний санхүү” сэдэвт хичээлийг 54 цаг буюу 108 цагийн хичээлийн хөтөлбөрийн саналыг тус тус үндэслэн хөтөлбөр боловсруулах ажлыг хамтран гүйцэтгэхээр болсон. Үүний дагуу Хөдөлмөрийн яам болон Монголбанк хамтран “Санхүүгийн суурь мэдлэг, хувь хүний санхүү” сэдэвт хичээлийн хөтөлбөрийг боловсруулан, мэргэжлийн боловсролын агуулгад тусгах ажлыг хийж гүйцэтгэхээр 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдөр 1116/383 тоот хамтран ажиллах гэрээг байгуулаад байна.

Залуу үед санхүүгийн мэдлэг олгох тэргүүлэх чиглэлийн хүрээнд “Хувь хүний санхүү” сэдэвт хичээлийг бүх их дээд сургуулийн хөтөлбөрт мэргэжил харгалзахгүй тусгуулах зорилгоор шаардлагатай хичээлийн агуулга, гарын авлага, сургагч багш бэлтгэх зэрэгт дэмжлэг үзүүлэн МУИС, Бизнесийн сургуультай хамтран ажиллахаар гэрээ байгуулан ажиллаж байна. Ингэхдээ үүнийн

саналын нээлттэй урилга нийт их дээд сургуулийн дунд зарлаж талуудын тэгш оролцоог хангаж ажилласан.

Цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр санхүүгийн мэдлэг олгох хүрээнд Олон нийтэд санхүүгийн мэдлэг олгох цахим хуудас болон “Төсөвчин” гар утасны програм хангамжийг нэвтрүүлэх үнийн санал авах урилгыг 2016 оны 3 дугаар сарын 07-22-ний өдрүүдэд Монголбанкнаас зарласан. Зарлагдсан хугацаанд материал хангалтгүй ирсэн гэж үзсэн тул үнийн санал авах хугацааг 4 дүгээр сарын 08-ны өдөр хүртэл дахин сунгахаар болсон. Энэ хугацаанд материал ирүүлсэн компаниудын шалгаруулалтыг 3 үе шаттайгаар явуулав. Шалгаруулалтын дүнд “Мизорн ХХК” шалгарч 2016 оны 5 дугаар сарын 30-ны өдөр 1116/302 тоот ажил гүйцэтгэх гэрээг байгуулан ажиллаж байна. Түүнчлэн Дэлхийн банкны ахлах зөвлөх Шон Манди цахим хуудасны агуулгад техникийн зөвлөмжийг үзүүлж байгаа. Энэ ажлын хүрээнд нийт 45 сэдвийн агуулгыг хүлээн авч, холбогдох засвар өөрчлөлтүүдийг хийж ажиллав. Үүнээс 36 сэдэв орчуулагдан ирсэн байна. Одоогоор цахим сайт төстийн шатанд явж байгаа бөгөөд III улиралд цахим сайтыг эхний туршилтын байдлаар ажиллуулахаар төлөвлөөд байна. Түүнийг дагалдсан гар утасны хувилбар болон гар утасны аппликейшныг мөн хамт туршилтаар ажиллуулна.

2016 оны 6 дугаар сарын 2-нд Банкны салбарын ажилтны өдрийг тохиолдуулан “Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх нь” сэдэвт панел 41 хэлэлцүүлгийг Банк, санхүүгийн академтай хамтран зохион байгуулав.

2016 оны 6 дугаар сарын 14-ний өдөр “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн хүрээнд “Мөнгө бол мөрөөдөлд хүрэх хэрэгсэл” сэдэвт хүүхдэд зориулсан санхүүгийн мэдлэг олгох зурагт (комик) номны 2 дахь дугаарыг нийт 3000 ширхэгийг хэвлүүлэн олон нийтэд тархааж эхлээд байна.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл

3. САНХҮҮГИЙН ЗАХЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД

ЗОРИЛТ 3.2 Санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн банкны зах зээлд оролцогчдын эрх ашгийг хамгаалах, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх цогц арга хэмжээг эрчимжүүлнэ.

“Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийн төслийг Дэлхийн банкны зөвлөмж, олон улсын туршлагад үндэслэн Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо холбогдох бусад байгууллагатай хамтран боловсруулсан. Түүнчлэн “Олон нийтийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх нь” сэдэвт семинарыг 2015 оны 1 дүгээр сарын 27- ны өдөр Дэлхийн банктай хамтран зохион байгуулснаас гадна иргэдийн санхүүгийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх чиглэлээр төрийн холбогдох байгууллагатай үүлзалт зохион байгуулж, цаашид хамтран ажиллах талаар санал солилцсон бөгөөд оролцогч байгууллагуудын хэрэгжүүлж байсан болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа ажлуудын талаар мэдээлэл авч, судалгаа хийсэн.

“Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр хэлэлцүүлсний үндсэн дээр баталж хэрэгжүүлэхээр байна.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэлийн төсөл

3. САНХҮҮГИЙН ЗАХЫН ДЭД БҮТЭЦ, ТҮҮНИЙ ИНСТИТУЦИЙГ БЭХЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД

Иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх талаар: Монголбанк хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, харилцагчийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх чиглэлд тодорхой ажлуудыг өнгөрсөн хугацаанд гүйцэтгэсэн болно. Тухайлбал, банкуудын үйл ажиллагааны шударга, зохистой байдлыг хангуулах, банкуудын мөнгөн хадгаламж, үнэт цаас, зээлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж, заавар журам, тэдгээрийн хэрэгжилт, банкнаас үзүүлсэн үйлчилгээний шимтгэл, хураамжийн нөхцөл, хүү бодох аргачлал зэргийг газар дээр нь шалгаж, түүний үр дүнд үндэслэн 2013 оны 12 дугаар сард “Банкны хүү бодох аргачлал, хүү, шимтгэл, хураамжийн мэдээллийн ил тод байдлын журам”-ыг батлан гаргасан. Дээрх журмыг баталснаар зээл, хадгаламжийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа хууль тогтоомж, заавар журмыг мөрдөх, хүүг нэгдсэн аргачлалаар тооцдог болох, хадгаламж, үнэт цаас, зээлийн үйл ажиллагаатай холбоотой шимтгэл, хураамжийг ил тод байлгах, харилцагчдыг зөв сонголт хийх боломжоор ханган банкуудын өрсөлдөөнийг нэмэгдүүлсэн арга хэмжээ болсон.

Цаашид иргэдийн санхүүгийн салбарын мэдлэгийг дээшлүүлж, санхүүгийн оновчтой шийдвэр гаргах чадвар, санхүүгийн сахилга батыг сайжруулах, банкны салбарын бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд дараах тодорхой ажлууд хийх шаардлагатай байна. Үүнд:

- Иргэдийн санхүүгийн боловсролын түвшинтэй үялдсан, өөрийн орны зах зээлийн нөхцөлд тохирсон “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг холбогдох бусад байгууллагуудтай хамтран боловсруулж цогц байдлаар хэрэгжүүлэх,
- Банк, санхүүгийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад шаардагдах суурь нөхцөл, эрсдэлийн судалгааг гүйцэтгэх.

Ингэснээр иргэдийн ижил төстэй санхүүгийн үйлчилгээнээс өөрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн оновчтой сонголт хийх чадвар нэмэгдэж, өрхийн санхүүгийн хариуцлага сайжран, улмаар санхүүгийн системийн тогтвортой байдлыг хадгалах чиглэлд томоохон алхам болох юм